

2008.10.22

Дугаар 227

“Өндөрхаан” ХК-ийн хувьцаа эзэмшихээр
тендер санал зарлахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11, Компанийн тухай хуулийн 58.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1.“Өндөрхаан” ХК-ийн нийт хувьцааны 63.9 хувь буюу 71,509 ширхэг хувьцааг эзэмшдэг Б.Дорлигоос тус компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 36.1 хувь буюу 40,370 ширхэг хувьцааг нэг бүрийг 100 төгрөгөөр худалдан авч тус компанийн хувьцааг 100 хувь эзэмшихээр тендер санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2008 оны 10 дугаар сарын 27 - ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2.Холбогдох хууль, журмын дагуу тендер саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, тендер саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан тендер саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэхийг хувьцаа эзэмшигч Б.Дорлигт үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-г даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ